ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## Иосеф Смит—Түүх 1:15–20

Анхны үзэгдэл

**Хам сэдэв**

1820 онд Иосеф Смит залуу байхдаа аль сүмд элсэн орохоо мэдэхийн тулд судалж мөн залбирч байлаа.

**Сургаал эсвэл зарчим**

Түүний залбирлын хариуд Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр Иосеф Смитэд үзэгдсэн юм.

**Хэрэгжүүлэх нь**

Иосеф Смит Эцэг ба Хүүг харсан гэдгийг мэдэх нь таны хувьд яагаад чухал вэ? Та энэхүү үйл явдлын талаарх гэрчлэлийг хүлээн авахын тулд юу хийсэн бэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 1:37–38

Есүс Христийн үгс бүгд биелэгдэх болно.

**Хам сэдэв**

Их Эзэн хэсэг 1-ийг Сургаал ба Гэрээн дэх бусад илчлэлтүүдийн оршил болгон мөн Түүний шүүлтийн талаар бүх хүмүүст анхааруулахын тулд илчилсэн юм.

**Сургаал эсвэл зарчим**

Есүс Христ болон Түүний үйлчлэгчдийн дуу хоолойгоор өгөгдсөн бошиглол ба амлалтууд бүгд биелэгдэх болно.

**Хэрэгжүүлэх нь**

Та бошиглогчид ба төлөөлөгчдийн дуу хоолойг Есүс Христийн өмнөөс тэднийг ярьж байгаа мэтээр хүлээн авдаг уу?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 6:36

Санаа бодол болгондоо Христ рүү харагтун.

**Хам сэдэв**

Иосеф Смит, Оливер Каудери нарыг Мормоны Номыг орчуулж байхад энэхүү илчлэлт өгөгджээ.

**Сургаал эсвэл зарчим**

Бид Есүс Христ рүү харах үедээ өөрсдийн эргэлзээ ба айдсыг даван туулж чадна.

**Хэрэгжүүлэх нь**

Та эргэлзээ ба айдастай тулгарсан үедээ эдгээрийг даван туулахын тулд Есүс Христ рүү хэрхэн харах вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 8:2–3

Илчлэлт оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь ирдэг.

**Хам сэдэв**

Их Эзэн Оливер Каудерид итгэлтэйгээр асууснаар илчлэлтийг хэрхэн хүлээн авч, таньж мэдэхийг заасан.

**Сургаал эсвэл зарчим**

Ариун Сүнс үнэнийг бидний оюун санаа ба зүрх сэтгэлд илчилдэг.

**Хэрэгжүүлэх нь**

Их Эзэн тантай хэзээ Ариун Сүнсээр дамжуулан харилцсан бэ? Та иймэрхүү харилцааг урих ямар зүйлсийг хийж болох вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 10:5

Ямагт залбир.

**Хам сэдэв**

Мартин Харрис Мормоны Номын гар бичмэлийн 116 хуудсыг алдсаны дараа Их Эзэн Иосеф Смитэд Сатаны санаануудыг ялж гарах нэгэн арга замыг заасан.

**Сургаал эсвэл зарчим**

Бурхан биднийг ямагт залбирвал Сатан ба түүний үйлчлэгчдийг ялан дийлэхэд маань туслах болно.

**Хэрэгжүүлэх нь**

Та уруу таталтыг илүү сайн давахын тулд залбирлаа хэрхэн сайжруулж чадах вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 13:1

Аароны санваар сэргээгдсэн.

**Хам сэдэв**

Иосеф Смит ба Оливер Каудери нарыг баптисм хүртээх эрх мэдлийн талаар залбирах үед Иохан Баптист тэдэнд үзэгдэж, тэднийг Аароны санваарт томилсон.

**Сургаал эсвэл зарчим**

Аароны санваар нь тэнгэр элчүүдийн тохинуулльн болон наманчлалын сайн мэдээний мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүдийг атгадаг.

**Хэрэгжүүлэх нь**

Таны амьдрал Аароны санваараар хэрхэн адислагдаж болох вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 18:10–11

Бодгалиудын үнэ цэнэ агуу юм.

**Хам сэдэв**

Их Эзэн бүх хүмүүнийг наманчлах хэрэгтэй хэмээн тайлбарласныхаа дараа Оливер Каудери, Давид Витмер нарыг бусдад наманчлалын талаар заалгахаар дуудсан.

**Сургаал эсвэл зарчим**

Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийн баталгаа болгон Есүс Христ бүх хүн төрөлхтөний зовлон шаналалыг өөртөө авсан билээ.

**Хэрэгжүүлэх нь**

Есүс Христ таны төлөө цагаатгалыг хийсэн гэдгийг мэдэх нь өөрийгөө Бурханы мэлмийд ямар үнэ цэнэтэй болохоо ойлгоход тань хэрхэн туслах вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 18:15–16

Бодгалиудыг Есүс Христэд авчирснаар агуу их баяр хөөр ирдэг.

**Хам сэдэв**

Их Эзэн Оливер Каудери, Давид Витмер нарт бодгалийн үнэ цэнийг зааж мөн тэднийг бусдад наманчлалын талаар заалгахаар дуудсан.

**Сургаал эсвэл зарчим**

Бид бусдыг Есүс Христэд ирэхэд нь тусалснаар агуу их баяр хөөрийг мэдэрдэг.

**Хэрэгжүүлэх нь**

Та хэн нэгнийг Есүс Христэд илүү ойр авчрахын тулд юу хийж чадах вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 19:16–19

Есүс Христ бид бүгдийн өмнөөс зовлон зүдгүүрийг амссан.

**Хам сэдэв**

Их Эзэн Шүүлтийн өдрийн тухай зааж мөн Өөрийн цагаатгах золиослолыг гэрчилснийхээ дараа Мартин Харрист гэм нүглүүдээ наманчлахыг тушаасан.

**Сургаал эсвэл зарчим**

Биднийг наманчилбал зовохгүй байж болохын тулд Есүс Христ бүх хүн төрөлхтний гэм нүглийн өмнөөс зовсон юм.

**Хэрэгжүүлэх нь**

Аврагчийн туулсан зовлон шаналалын тухай суралцах нь таныг наманчлах хүсэлтэй болгоход хэрхэн тусалж болох вэ? Танд наманчлах ёстой ямар нүглүүд байгаа вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 19:23

Аврагчаас суралтун, мөн Түүний үгсийг анхааратун.

**Хам сэдэв**

Мартин Харрис наманчилж, Мормоны Номын хэвлэлтэд туслахын тулд эзэмшил газрынхаа нэг хэсгийг зарж мөн Их Эзэнийг эрэлхийлэх ёстой хэмээн тушаагдсан.

**Сургаал эсвэл зарчим**

Бид Аврагчийг анхаарч, Түүнийг дагавал адислагдах болно.

**Хэрэгжүүлэх нь**

С ба Г 19:23-т дурдсан бүх зүйлс дээр сайжрах төлөвлөгөө зохионо уу.

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 25:13

Гэрээнүүдээ итгэлтэйгээр сахигтун.

**Хам сэдэв**

Их Эзэн Эмма Смитийг мөрдлөг хавчлагад орж, санаа зовсон үед нь тайвшруулж, зөвлөгөө өгсөн.

**Сургаал эсвэл зарчим**

Бид Бурхантай хийсэн гэрээнүүдээ сахиснаар баяр хөөр, тайвшралыг олж чадна.

**Хэрэгжүүлэх нь**

Та ямар ямар ариун нандин гэрээнүүдийг хийсэн бэ? Та эдгээр гэрээнүүдээ хэрхэн “итгэлтэйгээр сахиж” чадах вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 46:33

Ариун журам хийгээд цэвэр ариун байдлыг ямагт хэрэгжүүлнэ үү.

**Хам сэдэв**

Их Эзэн Ариун Сүнсний бэлгүүдийг илчилж мөн бүх зүйлийг Түүний хүслийн дагуу үйлдэхийн чухал болохыг заав.

**Сургаал эсвэл зарчим**

Бид ариун журамтай, цэвэр ариун байдалтай байхыг үргэлж хичээх ёстой.

**Хэрэгжүүлэх нь**

Та үргэлж ариун журамтай бодол санаа, үйлдэлтэй байхын тулд өнөөдөр юу хийх вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 58:27

Сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулна уу.

**Хам сэдэв**

Их Эзэн Миссурийн Индепенденст цугларсан олонд өөр хоорондоо зөвлөлдөж мөн бүх зүйл дээр тушаал хүлээн суухын оронд сайн зүйлс хийхийг зааварласан.

**Сургаал эсвэл зарчим**

Бид сайн зүйлсийг хийхээр сонгосноороо санаа сэтгэлээ бүрэн зориулж мөн зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой.

**Хэрэгжүүлэх нь**

Та гэр орон, сургууль, тойрог эсвэл салбартаа сайн зүйлсийг хийснээрээ санаа сэтгэлээ хэрхэн бүрэн зориулж болох вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 58:42–43

Бид наманчлахын тулд нүглүүдээ хүлээж мөн орхих ёстой.

**Хам сэдэв**

Их Эзэн Миссурид дөнгөж ирсэн гэгээнтнүүдэд Сионыг хэрхэн барьж мөн нүглүүдийнхээ өршөөлийг хүлээн авч болохыг заасан.

**Сургаал эсвэл зарчим**

Бид нүглүүдээ хүлээж, тэдгээрийг орхивол Их Эзэн биднийг өршөөн, нүглүүдийг маань дахин санахгүй.

**Хэрэгжүүлэх нь**

Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчдөө хүлээх хэрэгтэй ямар нэгэн нүгэл танд бий юу? Та нүглүүдээ орхихын тулд юу хийж чадах вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 64:9–11

Бид бүх хүмүүнийг уучлах ёстой.

**Хам сэдэв**

Их Эзэн Огайогийн Көртланд дахь Гэгээнтнүүдэд заахдаа, Иосеф Смитэд шүүмжлэлтэй хандахаа зогсоон, нэг нэгнээ уучилж эхлэхийг заасан.

**Сургаал эсвэл зарчим**

Бид бүх хүмүүнийг уучлах тушаалыг нь дагахгүй бол Бурхан бидний нүглийг мөн уучлахгүй.

**Хэрэгжүүлэх нь**

Та хэн нэгнийг уучлах хэрэгтэй байгаа юу? Уг хүнийг уучлах чадвартай болохын төлөө залбирна уу.

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 76:22–24

Есүс Христ амьд бөлгөө.

**Хам сэдэв**

Алдар суугийн гурван зэрэглэлийн талаарх үзэгдлийг хүлээн авах үедээ Иосеф Смит, Сидней Ригдон нар Есүс Христийг харсан.

**Сургаал эсвэл зарчим**

Есүс Христ амьд бөгөөд Бурхан Эцэгийн Цорын Ганц Хайртай Хүү нь билээ.

**Хэрэгжүүлэх нь**

Есүс Христ амьд гэдгийг та яаж мэддэг вэ? Аврагчийн талаарх гэрчлэлээ хуваалцана уу.

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 76:40–41

Есүс Христ цовдлогдож мөн бидний нүглийг үүрсэн юм.

**Хам сэдэв**

Алдар суугийн гурван зэрэглэлийн талаарх үзэгдлийг хүлээн авах үедээ Иосеф Смит, Сидней Ригдон нар мөхлийн хөвгүүдээс бусад—Бурханы бүх хүүхдүүд алдар суугийн хаант улсыг өвлөн авах болно гэдгийг мэдэж авсан.

**Сургаал эсвэл зарчим**

Сайн мэдээ нь биднийг бүхий л шударга бус явдлаас цэвэрлэгдэж болохын тулд дэлхийн бүх нүглүүдийг үүрэхээр ирсэн Есүс Христийн баярт мэдээ юм.

**Хэрэгжүүлэх нь**

Есүс Христийн сайн мэдээ таны амьдралд хэрхэн баярт мэдээ болдог вэ? Сайн мэдээг яагаад баярт мэдээ хэмээн нэрлэж байгааг та хэн нэгэнд ойлгоход нь туслахын тулд хэрхэн тайлбарлаж өгөх вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 78:19

Бүх зүйлийг талархалтайгаар хүлээн авагтун.

**Хам сэдэв**

Их Эзэн сүмийн удирдагчдад агуулах зохион байгуулж мөн өөрсдийн дунд байгаа ядуусыг халамжлах гэрээнд орохыг тушаасан.

**Сургаал эсвэл зарчим**

Бид Бурханаас хүлээн авсан бүхэндээ талархалтай байвал Тэрээр бидэнд нэмэлт адислалуудыг өгөх болно.

**Хэрэгжүүлэх нь**

Та ямар адислалуудаа талархалтай байдаг вэ? Өнөөдөр Бурханд талархлаа ямар арга замуудаар үзүүлж болох вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 82:10

Их Эзэн дуулгавартай хүмүүсийг адислах үүргийг хүлээдэг.

**Хам сэдэв**

Сүмийн ерөнхий чуулган дээр Их Эзэн Өөрийн үйлчлэгчдийг тэдний нүглүүдийн улмаас мөн Түүний урьд өгсөн илчлэлтүүдийг сахиагүйн төлөө буруутгасан байдаг.

**Сургаал эсвэл зарчим**

Бид Их Эзэнд дуулгавартай байвал Тэрээр биднийг адислах амлалтаа үргэлж биелүүлнэ.

**Хэрэгжүүлэх нь**

Их Эзэн Түүний зарлигуудыг дагасны төлөө таныг ямар арга замуудаар адисалсан бэ? Их Эзэний амлалтуудад итгэлтэй байхад тань энэ судар хэрхэн тусалдаг вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

## С ба Г 88:124

Залхуу мөн цэвэр ариун биш байхаа болигтун.

**Хам сэдэв**

Их Эзэн Өөрийн үйлчлэгчдэд номлолдоо бэлтгэж, ирээдүйд Аврагчтай уулзаж болохын тулд тодорхой зарлигуудыг өгсөн байдаг.

**Сургаал эсвэл зарчим**

Хэрэв бид шаардлагатайгаас илүү удаан унтахаа болин, орондоо эрт орж, эрт босч байвал бидний бие болон оюун сэргээгдэх болно хэмээн бидэнд амласан.

**Хэрэгжүүлэх нь**

С ба Г 88:124-өөс өөрийнхөө илүү бүрэн дүүрэн дагаж чадах нэг зарлигийг сонгоно уу. Та энэхүү зарлигт дуулгавартай байхын тулд энэ долоо хоногт юу хийх вэ?

5 Ялан дийлэгч болж гарахын тул чи ямагт [а]залбир; тийм ээ, чи Сатаныг ялж гарахын тулд, мөн түүний ажлыг дэмжиж байдаг Сатаны зарц нарын гараас зугтаахын тулд буюу.

---

2 Тийм ээ, болгоогтун, чамд ирж мөн [а]зүрх сэтгэлд чинь орших [б]Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд [в]ярих болно.
3 Эдүгээ, болгоогтун, энэ бол илчлэлтийн сүнс болой; болгоогтун, энэ бол Мосе Израилын хүүхдүүдийг [а]Улаан Тэнгисийн дундуур хуурай газраар гаталган авчирсан тэр сүнс бөлгөө.

---

36 Санаа бодол болгондоо над уруу [а]харагтун; бүү эргэлз, бүү ай.

---

37 Эдгээр [а]зарлигуудыг судлагтун, учир нь тэдгээр нь үнэн бөгөөд итгэмжлэгдсэн юм, мөн тэдгээрт буй бошиглолууд хийгээд [б]амлалтууд бүгд биелэгдэх болно.
38 Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, мөн би өөрийгөө зөвтгөх нь үгүй; мөн тэнгэр хийгээд газар үгүй болсон ч, миний [а]үг алга болох нь үгүй, харин миний өөрийн [б]дуу хоолой байна уу, эсвэл миний [в]үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь [г]яг адил, бүгд [д]биелэгдэх болно.

---

17 Намайг хүлсэн тэрхүү дайснаас миний бие чөлөөлөгдсөн нь удалгүй мэдэгдэв. Мөнөөх гэрэл над дээр тогтоход гялалзсан өнгө хийгээд [а]алдар сууг нь дүрслэхийн аргагүй [б]хоёр Хүн миний дээр агаарт зогсож байхыг би [в]харав. Тэдний нэг нь надтай ярьж, намайг нэрээр минь дуудан мөн нөгөөх уруугаа зааж хэлэв—*Энэ бол миний [г]Хайртай [д]Хүү, Түүнийг сонс!*
18 Их Эзэнээс [а]асуухаар ирсэн миний зорилго бол бүх урсгалуудаас аль нь зөвийг, мөн алинд нь би нэгдэж болохыг мэдэх явдал байв.

19 Тэдгээрийн алинд нь ч чи нэгдэх ёсгүй хэмээн надад хариулав, учир юун гэвэл тэдгээр нь бүгдээрээ [а]буруу ажээ; мөн тэдний бүхий л итгэл үнэмшил түүний мэлмийд жигшүүрт явдал бөлгөө; сүсэг бишрэл тунхаглагч тэд бүгдээрээ ялзарсныг, мөн "тэд уруулаараа надтай [б]ойр боловч [в]зүрх сэтгэлээрээ надаас хол байдаг; тэд хүмүүний [г]зарлигуудыг сургаал болгон заадаг, тэд бурханлиг байдлын [д]дүртэй боловч, түүний хүчийг үгүйсгэдэг" хэмээн надад хандсан мөнөөх Хүн хэлэв.

---

23 Надаас сурагтун, мөн миний үгсийг анхааргтун; миний Сүнсний [а]номхон дөлгөөн байдалд [б]алхагтун, мөн надаар дамжин [в]амар амгалан чамд байх болно.

---

16 Учрыг болгоогтун, хэрэв тэд [а]наманчлах аваас, тэд [б]зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг [в]амссан билээ;
17 Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд [а]зовох ёстой;
18 Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь—мөн намайг тэрхүү гашуун аяганаас [а]уухгүй, мөн айснаас эргэн буцахад хүргэж болохоор байсан билээ—
19 Гэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг [а]дуусгасан билээ.

---

15 Мөн, хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж мөн зөвхөн нэг [а]бодгалийг надад авчрах аваас, миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!
16 Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн [а]хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр хөөртэй байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад [б]авчрах юм бол та нарын [в]баяр хөөр хичнээн агуу байх билээ!

---

10 [а]Бодгалийн [б]үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийг санагтун;
11 Учир нь, болгоогтун, Их Эзэн чиний [а]Гэтэлгэгч махан бодид [б]үхлийг амссан билээ; иймийн тул бүх хүмүүн наманчилж, мөн түүнд ирж болохын тулд бүх хүмүүний [в]зовлонг тэрээр биеэрээ [г]амссан бөлгөө.

---

МИНИЙ нөхөд үйлчлэгч та нарт би Мессиагийн нэрээр, [а]тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд [б]наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх [в]баптисмын түлхүүрүүдийг атгагч [г]Аароны санваарыг [д]хүртээж байна; мөн энэ нь [е]Левийн хөвгүүд Их Эзэнд [ё]зөв шударга байдалд дахин өргөл өргөх хүртэл дэлхийгээс хэзээ ч дахин авагдахгүй байх болно.

---

9 Иймийн тул, та нар бие биенээ [а]уучлах ёстойг та нарт хэлнэ би; учир нь ах дүүгийнхээ зөрчлийг үл [б]уучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой.
10 Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би [а]өршөөх болно, харин бүх хүмүүнийг [б]уучлах нь та нараас шаардагдана.
11 Чи бид хоёрын хооронд Бурхан [а]шүүг, мөн чиний [б]үйлүүдийн дагуу чамайг шагнаг—хэмээн та нар зүрх сэтгэлдээ хэлэх ёстой.

---

42 Болгоогтун, нүглүүдээ [а]наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь [б]өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг нь цаашид [в]санах нь үгүй.
43 Хүн нүглүүдээ наманчилдаг эсэхийг та нар үүгээр нь мэдэж болно—болгоогтун, тэрээр тэдгээрийг [а]хүлээж мөн [б]орхих болно.

---

27 Үнэнээр би хэлнэ, хүмүүс сайн зарчимд [а]санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хийж, мөн туйлын зөв шударга байдлыг тохиолгохоор авчрах ёстой;

---

33 Мөн та нар [а]ариун журам хийгээд [б]цэвэр ариун байдлыг миний өмнө ямагт хэрэгжүүлэх ёстой. Бүр тийм буюу. Амен.

---

13 Иймийн тул, зүрх сэтгэлээ өргөж мөн баясагтун, мөн хийсэн гэрээнүүдээ итгэлтэйгээр сахигтун.

---

124 [а]Залхуу байхаа болигтун; цэвэр ариун биш байхаа боль; бие биенээсээ дутагдал [б]олж харахаа боль; шаардлагатайгаас илүү удаан унтахаа боль; та нар ядрахгүй байхын тулд; эрт босч бай, та нарын бие хийгээд оюун чинь амарч болохын тулд орондоо эрт орж бай.

---

10 Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр [а]үүрэг хүлээдэг; гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлалт байх нь үгүй.

---

19 Мөн бүх зүйлийг [а]талархалтайгаар хүлээн авдаг тэрээр алдар суут болгогдох болно; мөн энэ дэлхийн зүйлүүд, тийм ээ, бүр [б]зуу дахин, түүнд нэмэгдэх болно.

---

40 Мөн энэ бол тэнгэрээс гарах дуу хоолой нь бидэнд гэрчилсэн, [а]сайн мэдээ, баярт мэдээнүүд бөлгөө—
41 Иймхүү тэрээр, бүр Есүс, дэлхийн төлөө [а]цовдлогдохоор, мөн [б]дэлхийн нүглүүдийг [в]үүрэхээр, мөн дэлхийг [г]ариусгахаар, мөн үүнийг бүхий л шударга бус явдлаас нь [д]цэвэрлэхээр дэлхийд ирсэн бөлгөө;

---

22 Мөн эдүгээ, түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх, хамгийн сүүлчийн [а]гэрчлэл юм: Тэр [б]амьд бөлгөө!
23 Учир нь бид түүнийг бүр [а]Бурханы баруун гар талд [б]харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн [в]Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ—
24 Иймхүү [а]түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс, [б]дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн [в]хөвгүүд хийгээд охид нь бөлгөө.

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

### С ба Г 89:18–21

Мэргэн ухааны үгийн адислалууд

**Хам сэдэв**
Их Эзэн хор нөлөөтэй зүйлсээс зайлсхийж мөн эрүүл хүнс хүртэхийг гэгээнтнүүдэд зааварласныхаа дараа дуулгавартай байдлын төлөөх адислалуудыг амласан.

**Сургаал эсвэл зарчим**
Бид Мэргэн ухааны үгийг дагавал эрүүл мэндийн адислалууд, мэдлэгийн агуу сан хөмрөгүүд, хүч чадал болон хамгаалалтыг хүлээн авах болно.

**Хэрэгжүүлэх нь**
Та Мэргэн ухааны үгийг дагаснаар хэрхэн адислагдсан бэ? Энэхүү зарлигт дуулгаваргүй байвал ямар үр дагавар гарах вэ? Мэргэн Ухааны Үгийг илүү сайн дагахын тулд танд хийж чадах өөр зүйл байгаа юу?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

### С ба Г 107:8

Мелкизедек санваар нь сүнсний зүйлүүдэд үйлчилдэг.

**Хам сэдэв**
Мелкизедек санваар нь эртний өдрүүд дэх агуу дээд пристийн дараа дуудагдсан гэдгийг Их Эзэн илчилсэн байдаг. Их Эзэн санваарын алба ба үүргүүдийг тодорхойлсон.

**Сургаал эсвэл зарчим**
Мелкизедек санваар нь дээд буюу илүү агуу санваар бөгөөд сүнсний зүйлүүдэд үйлчилдэг.

**Хэрэгжүүлэх нь**
Та Мелкизедек санваар атгагчдын үйлчлэлээр хэрхэн адислагдаж байсан бэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

### С ба Г 121:36, 41–42

Зөв шударга ёсны зарчмууд нь санваарт хүчийг өгдөг.

**Хам сэдэв**
Иосеф Смит Либерти шоронд бичсэн захиандаа зөв шударга хүмүүст өгөгдөх Их Эзэний тайтгарлын үгс ба санваар атгагч зөв шударга бусчуудад ирэх үр дагавруудыг тэмдэглэсэн байдаг.

**Сургаал эсвэл зарчим**
Санваарын хүчийг зөвхөн зөв шударга ёсны зарчмуудаар удирдах боломжтой.

**Хэрэгжүүлэх нь**
Таны мэдэх санваар атгагчид С ба Г 121 дээрх шинж чанаруудыг хэрхэн харуулдаг вэ? Эдгээр шинж чанаруудыг санах нь бусадтай харилцахад тань хэрхэн тусалдаг вэ?

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

### С ба Г 130:22–23

Эцэг, Хүү хоёр мах хийгээд ясан биетэй.

**Хам сэдэв**
Иосеф Смит асуултад хариулахдаа сургаалын хэд хэдэн мөн чанарыг тодруулж мөн нарийвчлан тайлбарласан байдаг.

**Сургаал эсвэл зарчим**
Эцэг, Хүү хоёр мах хийгээд ясан биетэй бөлгөө, харин Ариун Сүнс бол Сүнсэн хүн юм.

**Хэрэгжүүлэх нь**
Бурхан Тэргүүтэний гишүүд нь гурван тусдаа гэдгийг бусдад заахдаа ашиглаж болох нэмэлт судруудыг олно уу.

ТӨГС ЭЗЭМШИХ СУДАР

### С ба Г 131:1–4

Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ

**Хам сэдэв**
Иосеф Смит Иллинойн Рамуст айлчлах үеэрээ Селестиэл гэрлэлтийн ач холбогдлын тухай заасан.

**Сургаал эсвэл зарчим**
Бид Селестиэл хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөлийг авахын тулд гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орсон байх ёстой.

**Хэрэгжүүлэх нь**
Та гэрээн дэх гэрлэлтийн адислалуудыг хүлээн авахад бэлтгэхийн тулд юу хийж болох вэ?

## Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн уншлагын хүснэгт

| Сургаал ба Гэрээ Ном үнэн болох тухай Арванхоёр Төлөөлөгчийн гэрчлэл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Иосеф Смитийн—Түүх | 1 | | | | | |
| Сургаал ба Гэрээ | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |
| | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 |
| | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 |
| | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 |
| | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 |
| | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 |
| | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 |
| | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 |
| | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 |
| | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 |
| | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 |
| | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 |
| | 97 | 98 | 99 | 100 | 101 | 102 |
| | 103 | 104 | 105 | 106 | 107 | 108 |
| | 109 | 110 | 111 | 112 | 113 | 114 |
| | 115 | 116 | 117 | 118 | 119 | 120 |
| | 121 | 122 | 123 | 124 | 125 | 126 |
| | 127 | 128 | 129 | 130 | 131 | 132 |
| | 133 | 134 | 135 | 136 | 137 | 138 |
| | Албан тунхаг 1 | | | Албан тунхаг 2 | | |
| Итгэлийн тунхаг | 1 | | | | | |


## Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүхийн уншлагын хүснэгт

| Сургаал ба Гэрээ Ном үнэн болох тухай Арванхоёр Төлөөлөгчийн гэрчлэл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Иосеф Смитийн—Түүх | 1 | | | | | |
| Сургаал ба Гэрээ | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |
| | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 |
| | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 |
| | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 |
| | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 |
| | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 |
| | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 |
| | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 |
| | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 |
| | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 |
| | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 |
| | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 |
| | 97 | 98 | 99 | 100 | 101 | 102 |
| | 103 | 104 | 105 | 106 | 107 | 108 |
| | 109 | 110 | 111 | 112 | 113 | 114 |
| | 115 | 116 | 117 | 118 | 119 | 120 |
| | 121 | 122 | 123 | 124 | 125 | 126 |
| | 127 | 128 | 129 | 130 | 131 | 132 |
| | 133 | 134 | 135 | 136 | 137 | 138 |
| | Албан тунхаг 1 | | | Албан тунхаг 2 | | |
| Итгэлийн тунхаг | 1 | | | | | |

[а]CЕЛЕСТИЕЛ алдар сууд гурван тэнгэр буюу зэрэглэл буй;
2 Мөн [а]хамгийн дээдхийг нь олж авахын тулд хүн санваарын энэхүү ариун жаягт [[б]гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээг хэлж буй] орох ёстой;
3 Мөн хэрэв тэрээр үгүй аваас, тэрээр үүнийг олж авч чадах нь үгүй.
4 Тэрээр нөгөөд нь орж болно, гэвч тэр нь түүний хаант улсын төгсгөл болой; тэрээр [а]өсөн нэмэгдэж үл чадна.

22 [а]Эцэг хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан [б]биетэй болой; Хүү ч бас адил бөлгөө; харин [в]Ариун Сүнс бол мах хийгээд ясан биегүй харин Сүнсэн хүн буюу. Ийм бус байх аваас, Ариун Сүнс бидэн дотор орших чадах нь үгүй бөлгөө.
23 Хүн [а]Ариун Сүнсийг хүлээн авч болно, мөн энэ нь түүн дээр бууж ирж болох бөгөөд түүнтэй хамт үлдэх нь үгүй.

36 Санваарын [а]эрхүүд нь тэнгэрийн [б]хүчтэй салшгүй холбоотой байдаг, мөн тэнгэрийн тэрхүү хүч нь [в]зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар хянагдаж ч мөн шийдвэрлэгдэж ч үл чадах бөлгөө.

41 Хүч буюу нөлөө нь санваарын ариун журмаар төдийгүй гагцхүү [а]сэнхрүүллээр, [б]тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар тэтгэгдэж чадах буюу байх ёстой ажгуу;
42 Нинжин сэтгэл, мөн цэвэр мэдлэгээр энэ нь [а]зусардалтгүйгээр мөн [б]зальмэхгүйгээр оюун санааг агуу ихээр өргөжүүлэн тэлдэг

8 Мелкиседек санваар нь ерөнхийлөн удирдах эрхийг атгадаг бөгөөд мөн дэлхийн бүх үед сүм дэх бүх албан тушаалд сүнсний зүйлүүдэд үйлчлэх хүч болон [а]эрх мэдэлтэй байдаг.

18 Мөн зарлигуудад дуулгавартай байдалд алхан, эдгээр айлдваруудыг санаж мөн хэрэгжүүлдэг бүх гэгээнтнүүд хүйсэндээ [а]эрүүл энхийг хийгээд яснууддаа чөмөг хүлээн авах болно;
19 Мөн [а]мэргэн ухаан хийгээд [б]мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах болно;
20 Мөн [а]гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно.
21 Мөн устгагч тэнгэр элч, Израилын хүүхдүүдийн [а]дэргэдүүр өнгөрсний адил тэдний дэргэдүүр өнгөрч, мөн тэднийг хөнөөхгүй байх болно хэмээх [б]амлалтыг Их Эзэн бибээр тэдэнд өгч байна. Амен.

## Өдөр тутмын судрын уншлагын хүснэгт

| 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 |
| 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 |
| 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 |
| 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 |
| 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 |
| 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 |
| 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 |
| 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 |
| 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 |
| 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 |
| 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 |
| 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 |
| 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 |
| 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 |
| 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 |
| 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 |
| 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
| 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 |
| 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 |
| 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 |
| 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 |
| 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 |
| 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 |
| 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 |
| 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 |
| 29 | (29) | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 |
| 30 | | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| 31 | | 31 | | 31 | | 31 | 31 | | 31 | | 31 |

MONGOLIAN
4 02104 94363 2
10494 363

## Өдөр тутмын судрын уншлагын хүснэгт

| 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 | 3 |
| 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 | 4 |
| 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 | 6 |
| 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 | 7 |
| 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 | 8 |
| 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 | 9 |
| 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 |
| 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 |
| 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 | 12 |
| 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 | 13 |
| 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 | 14 |
| 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 | 15 |
| 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 | 16 |
| 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 | 17 |
| 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 | 18 |
| 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 | 19 |
| 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 | 20 |
| 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 | 21 |
| 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 | 22 |
| 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 | 23 |
| 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 | 24 |
| 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 | 25 |
| 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 | 26 |
| 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 | 27 |
| 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 | 28 |
| 29 | (29) | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 | 29 |
| 30 | | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 | 30 |
| 31 | | 31 | | 31 | | 31 | 31 | | 31 | | 31 |

*Doctrine and Covenants Scripture Mastery Cards.* Mongolian. -ын орчуулга
© 2013 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 1/13. Орчуулгын зөвшөөрөл: 1/13.10494 363